

1987-ын 1003 оны А282-р захирамжаар 173
хүтчингүй.

БНМАУ-ын ХУДАЛДАА, БЭЛТГЭЛИЙН ЯАМ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ын ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1986.11.28

Дугаар 383/259

Улаанбаатар
хот

Үндэсний хоолны газар ажиллуулах
т у х а й

ТОГТООХ нь:

Нэг. Улаанбаатар хотын Сүхбаатарын районы нийтийн хоолны трестийн Монгол зоогийн газрыг 1987 оны 01 дугаар сарын I-нээс Монгол үндэсний хоолны "Монгол зоог" кафе болгон ажиллуулсугай.

Хоёр. Улаанбаатар хотын нийтийн хоолны удирдах газар /н. Урианхай/-т ДААЛГАХ нь:

а/ "Монгол зоог" кафе д худалдаа бэлтгэлийн яамны сайдын 1985 оны ЗИ4 дүгээр тўшаалаар баталсан хоолны жор технологийг хэрэглэж, кафены ажиллах журмыг энэ 12 дүгээр сард багтаан баталж мөрдүүлэх;

б/ "Монгол зоог" кафе д хэрэглэх үндэсний өвөрмөц хэв, загвар бүхий аяга, таваг сав, үйлчилгээний багаж хэрэгслийг 1987 оноос эхлэн захиалж хийлгүүлэх арга хэмжээ авах;

в/ "Монгол зоог" кафены зөөгч, заалын зохион байгуулагч, бүфетын худалдагч, хаалгач нарын үйлчилгээний үед хэрэглэх үндэсний хийц загвар бүхий ажлын тусгай хувцасыг энэ онд багтаан хийлгэж хангах;

г/ "Монгол зоог" кафе д ажлын дадлага түршлагатай өндөр мэргэжлийн тогооч, зөөгч ажиллуулах;


Гурав. "Монгол зоог" кафены хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг үйлчилгээний нэгдүгээр зэрэглэлийн рестораны нэг адилаар бодож шинэчлэн тогтоож өгөхийн хамт 1987 оны I дүгээр сарын I-нээс шууд хангадаг журамд шилжүүлэн ажиллуулахыг Хотын төлөв-

2.

лөгөөний комисс /н.Ганбаатар/, Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/, Мах консервийн комбинат /н.Жамъяансүрэн/, Сүүний үйлдвэр /н.Дамдинсүрэн/, Хүнсний бараа худалдааны нэгдэл /н.Шагдар/-д тус тус даалгасугай.

Дөрөв. "Монгол зоог" кафед захиалгаар хийх бүтээгдэхүүний нэмэгдлийн асуудлыг ^{Захиалга} холбогдох газарт оруулан 1987 оны I улиралд багтаан шийдвэрлүүлэхийг Нийтийн хоолны хэлтэс /н.Рамазан/-т даалгасугай.

Тав. "Монгол зоог" кафены үйлдвэрлэлийн цех, агуулах, хөргөх байгууламжийг өргөтгөх, кулинарын дэлгүүр шинээр байгуулах шаардлагыг үндэслэн тус кафе байрлаж буй 55 айлын сүүцнаас 2 айлын сүүцыг 1987 оны эхний хагаст багтаан сүүлж өгөхийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга /н.Энэбиш/-д, кафены өргөтгөлийн зураг төсвийг 1986 онд багтаан гаргахыг Хотын барилга архитектор төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т зураг төсвийн дагүү 1987 онд засвар өргөтгөл хийхийг худалдаа бэлтгэлийн яамны барилга засварын контор /н.Банзрагч/, Хотын нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т тус тус даалгасугай.



ХУДАЛДАА, БЭЛТГЭЛИЙН
ЯАМНЫ САМД

[Handwritten signature]

Б.ШАРАВСАМБУУ



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Handwritten signature]

С.МОНУЖАРГАЛ